



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 6/47

Хэрлэн сум

Б.Энх-Уянгыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2, 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоолын хавсралт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн 2024 оны 38 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батжаргалын Энх-Уянга нь төрийн албаны тусгай шалгалтад тэнцсэн тул Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн туршилтын 6 сарын хугацаатай томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ч.Баярцолмон Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Ш.Эрдэнэжаргал Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

С.Чулуунцэцэг Няравын үүргийг түр орлон гүйцэтгэгч

3. Б.Энх-Уянгын цалинг ТЗ-8 зэрэглэлээр тогтоон, 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар, төрийн

231030139

2.

алба хаасан хугацааны нэмэгдлийг 1 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Энх-Уянгад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА